



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/488

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай XIX/08 тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Алтаргана-2024” олон улсын XV наадамд хүрэлцэн ирэх хүндэт зочдын гарын бэлэгний төсвийг 44,860,000 (дөчин дөрвөн сая найман зуун жаран мянга) төгрөгөөр хавсралтын дагуу баталсугай.

2. Хүндэт зочдын гарын бэлгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бэлтгэхийг тус наадамд хүрэлцэн ирэх хүндэт зочдыг хүлээн авч, байрлуулах салбар хороо (Д.Алтаншагай)-д даалгасугай.

3. Дээрх хөрөнгийг Булган аймаг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Байгаль орчныг хамгаалах зорилгоор байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



0324910784

Аймгийн Засаг даргын 2024 оны
08 дугаар сарын 02 өдрийн А/148
Захирамжийн хавсралт

**"АЛТАРГАНА-2024" ОЛОН УЛСЫН XV НААДАМД ХҮРЭЛЦЭН
ИРЭХ ХҮНДЭТ ЗОЧДЫН ГАРЫН БЭЛГИЙН ТӨСӨВ**

№	Бэлтгэх зүйлс	Тоо	Нэгжийн үнэ /төгрөгөөр/	Дүн /мян.төг/
1	ОХУ-ын Буриад улсын Ерөнхийлөгчийн гарын бэлэг	1	4,500,000	4500.0
2	ОХУ-ын Буриад улсын Ардын их хурлын даргын гарын бэлэг	1	4,000,000	4000.0
3	ОХУ-ын Холбооны зөвлөлийн гишүүний гарын бэлэг	1	4,000,000	4000.0
4	ОХУ-ын Эрхүү мужийн амбан захирагчийн орлогчийн гарын бэлэг	1	2,000,000	2000.0
5	ОХУ-ын Буриад улсын Соёлын сайд, Эрүүл мэндийн сайд нарын гарын бэлэг	2	2,450,000	4900.0
6	Түлхүүрийн оосор	250	22,000	5500.0
7	Алтаргана наадмын түүх дурсгалын ном	330	50,000	16500.0
8	Арвайн гурил	250	5,000	1250.0
9	Ааруул	70	3,000	210.0
10	Бэлгийн уут	250	8,000	2000.0
	НИЙТ			44860.0